

аргаар мөнгө олох зорилгоор хил дамнасан наймаа, хар тамхи мансууруулах бодисын тээвэрлэгч болох зэрэг эрсдэлүүд багасах боломжтой юм.

ДҮГНЭЛТ: Хилийн аюулгүй байдал нь төр, нийгэм, иргэдийн язгуур ашиг сонирхолыг хилийн орон зайд хангах замаар үндэсний хийгээд, улс хоорондын аюулгүй байдлыг хангах тогтвортой урьдчилсан нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Үүнтэй холбогдуулан хил орчмын нутаг дэвсгэрт гарч болох аюулуудыг арилгах, саармагжуулах зорилгоор төрөөс авч хэрэгжүүлж байгаа улс төр, нийгмийн шинжтэй арга хэмжээнүүдийн зэрэгцээ эдийн засаг, хун ам зүй, зэргэлдээ улсаас манай улсын нутаг дэвсгэрт үйлдэж болзошгүй шашин-соёлын түрэмгийлэл, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл, гадаадын террорист байгууллагуудын уйл ажиллагаа, улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт явагдаж буй нийгэм, улс төрийн байдал, хар тамхины наймааны зөөвөр зэрэг сөрөг үзэгдлүүдийн үндсийг судлан, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд таслан зогсоох талаар төрөөс тусгайлан бодлого боловсруулж, хүний аюулгүй байдлыг хангах /хил орчмын нутаг дэвсгэрт оршин суугч иргэдийн/ талаар тодорхой арга хэмжээг дэс дараатайгаар авч хэрэгжүүлэх асуудал онцгой чухлаар тавигдаж байна.

УЛСЫН ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАМГААЛАЛТЫН АРГААР ХАНГАХ НЬ

Н.ГАНТӨМӨР

ХСИС-ийн Хууль сахиулах удирдлагын академийн
8042 дугаар дамжааны суралцагч, хошууч;

В.Пүрэвбаасан

ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн
Хилийн албаны удирдлага, стратегийн профессорын
багийн дэд профессор, хурандаа

Товч агуулга:Тус илтгэлээр улсын хилийн аюулгүй байдлын тухай ойлголт, түүний мөн чанар, түүнд нөлөөлөх хүчин зүйл, тэдгээрийн харилцан хамаарал, хилийн аюулгүй байдлыг хамгаалалтын аргаар хангах тухай авч үзлээ.

Түлхүүр үг:Монгол улсын тусгаар тогтнол, Хилийн аюулгүй байдал, Улсын хил хамгаалалт.

Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал нь улсын хилийн найдвартай хамгаалалттай шууд холбоотой. Улсын хил хамгаалалтыг өргөн утгаар нь улсын хилийн аюулгүй байдлыг хангах явдал гэж ойлгож болно.

Тэгвэл хилийн аюулгүй байдал нь улс орны аюулгүй байдлын үндсэн бүрэлдэхүүн хэсгийг бүрдүүлдэг ба аливаа улс орны дотоодын тогтвортой байдал нь хилийн аюулгүй байдалтай нягт холбоотой байдаг.

Хүн төрөлхтний жам ёсны хөгжлийн дагуу зарим улс үндэстэн усах, салах, өөр хоорондоо нэгдэх, шинээр улс орон бий болох үйл явц явагдсаны хэрээр улсын хилийн үүсэл хөгжил ч энэ замаар явж ирсэн. Улс төрийн онолын үүднээс авч үзвэл улсын хил нь улс орнуудын харилцаанаас ихээхэн хамааралтай байдаг. Иймээс улсын хилийн аюулгүй байдлыг хангах асуудал зүй ёсоор дэвшигдэн гарч ирдэг байна.

Монгол Улсын хил ямар ч нөхцөлд баталгаажиж, халдашгүй дархан байж хилийн орон зайн аюулгүй байдал хангагдсанаар Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрх жинхэнэ ёсоор хэрэгжинэ¹.

Монгол Улсын хил, түүний хамгаалалт нь нийт ард иргэдийн эрх ашиг учраас бүх нийтийн хүлээх ариун үүрэг мөн. Гэвч улсын хил гэдэг өөрийн гэсэн бие даасан алба учраас, тэрхүү албыг хариуцаж биечлэн гүйцэтгэх, улс орны хэмжээнд бодлогоор уялдуулан зохион байгуулах хэрэгжүүлэх субьектгүйгээр Монгол Улсын үндэсний аюулгүй байдал бүрэн баталгаажих боломжгүй юм. Энэ бол обьектив шинжтэй, бодит байдлыг илэрхийлсэн нийгэм-улс төрийн өвөрмөц үзэгдэл гэдгийг дэлхий даяар хүлээн зөвшөөрч, хил хамгаалах субьектыг янз бүрийн хэлбэрээр, агуулга нэгтэйгээр практикт хэрэгжүүлж байна.

Харин улсын хилийг манах, хамгаалах үүрэг хүлээсэн тодорхой субьектын чанар байдлаас бүхэлдээ тухайн улсын хилийн халдашгүй дархан байдлын нүүр царай харагддаг, бас субьектив шинжтэй үзэгдэл түүнийг дагалдаж байдаг.

Энэ утгаар авч үзвэл Монгол Улсын хилийн хүрээний асуудлыг ялангуяа хил хамгаалалтын удирдлагын тогтолцоог шийдвэрлэхэд зохицолдоонт чанар онцгой чухал байр эзлэх ёстой болж байна. Зохицолдоонт чанар гэдэг нь философийн үүднээс үзвэл “үйл явц, үзэгдлийн тодорхой үр дүнд өргөн буюу томъёолсон утгаар зорилгод хүрэх шинж” гэж үздэг байна. Улсын хилийн баталгаажилт, хамгаалалтад зохицолдоонт чанар нь хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт байх ёстой болов.

Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын үзэл баримтлалын дөрөвдүгээр бүлэгт “Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагууд, нутгийн өөрөө удирдах байгууллагууд нь энэхүү үзэл баримтлалын үзэл санааг Монгол Улсын хууль, хууль тогтоомж болон эрх зүйн

бусад холбогдох актаар бэхжүүлж, тус тусын эрх хэмжээний дотор хэрэгжүүлэх үүрэгтэй”¹ гэсэн байна.

Монгол Улсын хилийн аюулгүй байдал гэдэг тодорхойлолт бий болж хэрэгжсэнээр Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал улсын хилийн орон зайн хүрээнд бүтээлчээр хэрэгжих боломж нээгдэх болно. Хилийн баталгаажилт, хамгаалалтын бэлтгэл, явц, үр дүнг хангах, хянан зохицуулах механизм бий болсноор хилийн хүрээний бүх асуудал үр дүнтэй, бодитой хэрэгжих нөхцөл бүрдэнэ. Монгол Улсын хилийн аюулгүй байдал гэдэг бол мөн чанартаа үндэсний аюулгүй байдал улсын хил болон хилийн орон зайн хүрээнд хангагдсан байдлыг хэлнэ.

Монгол Улсын хил, түүний хамгаалалтын эрх зүйн тулгуур зарчим нь Монгол Улсын Үндсэн хууль, хилийн тухай хууль, төрийн бусад эрхийн актанд үндэслэгдэнэ.

Монгол Улс дэлхийн аль ч гүрэнтэй ижил төвшинд бүрэн эрхтэй харилцах үндсэн хуульт бие даасан, тусгаар тогтносон, Нэгдсэн үндэсний байгууллагын бүрэн эрхт гишүүн мөн. БНХАУ, ОХУ-тай харилцан тохиролцон тогтоон тэмдэглэсэн улсын хилээ халдашгүй дархан байна² гэж Үндсэн хуулиар тунхагласан. Энэ нь монголын ард түмэн, хилчдийн үндэсний мөнхийн бахархал юм.

Монгол Улсын газар нутаг баян тансаг, агаар цэлмэг, газрын хэвлийн баялаг арвинтай, цөөхөн боловч золбоолог, баатарлаг ард түмэнтэй улс. Энэ чанар нь олон зууныг дамжин бусад улс гүрний анхаарлыг гойд татаж ирсэн бөгөөд цаашид улсынхаа тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн байдалд аюул занал учирч болохыг мартаж болохгүй.

Иймээс Монгол Улсын хилийн халдашгүй, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангахад дараах зарчмуудыг харгалзан үзнэ. Үүнд:

Улсын хилийн талаар энхийг эрхэмлэсэн гадаад бодлого баримтлан Монгол Улсын газар нутагт түрэмгийлэх, өөрийн нутгийн хавсарга болгохоор хүчээр сүрдүүлэх, хүч хэрэглэн түрэмгийлэхээс сэрэмжлэн аюулгүй таатай орчин бүрдүүлэх;

Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдлын илэрхийлэл болгон нэгэнт тогтоон тэмдэглэгдсэн улсын хилийн халдашгүй найдвартай байдлыг хангах;

Монгол Улсын Засгийн газраас зөвшөөрөгдсөн хилийн боомтоор дэлхий нийтээр болон манай улсаас хүлээн зөвшөөрсөн эрх бүхий баримт бичгээр зорчигчид, тээврийн хэрэгслийг олон улсын жишгээр нэвтрүүлэх, хийгдэх

¹ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал.Цахим эх сурБanucwwww.legalinfo.mn

² Монгол улсын үндсэн хууль. Цахмн эх сурBa:ra<:www.lcgalinfb.mn

хилийн хяналтыг ардчилал, хүний эрхийг дээдлэх зарчимд нийцүүлэн хууль зүйн дагуу явуулах;

Хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрхэмд үзэж гарсан зөрчлийг энхийн аргаар хууль зүйн дагуу шийдвэрлэх;

Улсын хилийн найдвартай хамгаалалтыг хадгалан, хөрш улстай хилээ харилцан ашигтайгаар хамтран хамгаалах зарчим баримтлах;

Монгол Улсын хилийг аюулгүй байлгах нөхцөлийн нэг чухал хэсэг нь юуны урьд тогтоогдсон хилийг өөрчлүүлэхгүй байх, улсын хилийг зөрчих аливаа оролдлого гаргуулахгүй байлгах нөхцөл бүрдүүлж эдгээр байдал үйлдэгдсэн тохиолдолд түүнийг газар авахуулахгүй зөв шийдвэрлэх явдал юм.

Үүнийг манай улс Төрөөс хилийн талаар баримтлах бодлогын хүрээнд хэрэгжүүлдэг.

Монгол Улсын хилийг аюулгүй байлгах нөхцөлийн дараагийн хэсэг нь улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал, ялангуяа хилийн халдашгүй дархан байдлыг хүндэтгэн үзэх орчныг юуны урьд хил орчмын аймаг, сумын нутагт хангаж хэвшүүлэх явдал мөн ¹. Ингэснээр үндсэн хуулиар бататгасан төр. эрх, эрх чөлөөг хилийн орон зайн хүрээнд тууштай хэрэгжүүлэх бололцоо бүрдэнэ.

Монгол Улсын хил орчмын эдийн засгийн аюулгүй байдал гэдэг нь хилийн орон зайн хүрээнд эдийн засгийн тэнцвэртэй байдал бий болгож хилчид, хил орчмын иргэдийн хэрэгцээг хангаж улсын хилийн тогтоосон боомтоос бусад газраар зорчигч тээврийн хэрэгсэл, бараа таваар нэвтрүүлэхгүй, арилжаа худалдаа хийлгэхгүй байх, мал хил давуулахгүй, хилийн орчимд элдэв халдварт өвчин, гал түймэр зэрэг аюул гамшиг гаргуулахгүй байх нөхцөл бүрдүүлж хэрэгжүүлэх чадварыг хамааруулж ойлгож болно.

Олон улсын болон орон нутгийн чанартай боомтыг цаг тухайд нь нөхцөл байдлыг нь зөв харгалзан байгуулж, ажиллагааны чадавхыг хэр зэрэг үр дүнтэй ашигласнаас эдийн засгийн аюулгүй байдал багагүй шалтгаална.

Монгол Улсын хил орчмын экологи, байгаль орчны аюулгүй байдал гэдэгт хил орчмын газар нутгийн байгалийн унаган төрхийг хадгалах, зүй зохистой ашиглах, найдвартай нөхцөл бий болгохыг хамааруулан үзэж болно. Үүнийг хилийн зөрчил үйлдэх шалтаг шалтгаан болгохгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Энэ зорилгоор хилийн нуур гол, мөрөн, хил орчмын ан амьтад, ой мод, байгалийн ховор баялаг бүхий бүсийн хамгаалалтад онцгой анхаарах шаардлагатай.

Монгол Улсын хил орчмын нутгийн соёл иргэншлийн аюулгүй байдалд юуны урьд хил орчмын нутагт амьдарч аж төрөх найдвар хүлээсэн иргэд нь

¹ ХСИС Хил судлалын шинжлэх ухааны онол практикийн зарим асуудал.УБ.2014

үндэсний хэл, бичиг, түүх соёл. заншлаа дээдэлж улсын хилийн ойролцоо оршин суух газар нутгаа чөлөөтэй эзэмшиж, аюулгүй амар тайван амьдрах. хилчдээс тэдний зан заншлыг ёсчлон дээдлэхийн хамт иргэдээс хилчдээ хүндэтгэн хайрлаж. хил хамгаалалтад идэвхтэй оролцох аятай нөхцөл бүрдүүлэхийг хамааруулан үзнэ.

Манай улсын хил орчмын нутгийн гадаад талд ихэвчлэн монгол үндэстэн, угсаатан амьдардаг онцлогтой. Энэ нь манай улсын хувьд ашигтай, давуу талтай боловч нөгөө талаас дайны үеүдэд дайсагнагч этгэдүүд бодлого, зорилгодоо хүрэхийн тулд манай улсын эсрэг явуулсан үйл ажиллагааныхаа үзүүрт нутгийн зарим монгол үндэстэнг хэл, зан заншлын онцлогийг харгалзан хүчээр ашиглаж байсан сургамжийг мартах учиргүй юм.

Монгол Улсын хил орчмын цэргийн аюулгүйн байдал гэдэгт нэг талаар зэргэлдээх улсаас манай улсын хилийг зөрчихгүй байх, хил зөрчигчийг цэргийн хүчээр дэмжихээс зайлсхийх, цэргийн хүчээр сүрдүүлэх, зэвсэгт халдлага үйлдэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх явдлыг хамааруулж болох юм. Нөгөө талаар тус улсын зүгээс улсын хилийг элдэв хэлбэрээр зөрчих, давтан үйлдэх явдал гаргуулахгүй байх, хилийн зөрчил, маргааныг зэвсэгт мөргөлдөөн, дайнд хүргүүлэхгүйгээр энхийн аргаар шийдвэрлэхийг хэлдэг байна.

Аюулгүй байдлыг хангах гэдэг нь учирч болзошгүй аюулыг баттай мэдээлэл, нарийн судалгаа, тооцооны үндсэн дээр урьдчилан бодитойгоор төсөөлөн харж мэдэх, тухайн аюулаас сэргийлэхийн тулд бүх бэлтгэлээ урьдчилан хангаж шийдвэртэй ажиллаж амжилтад хүрэх чадвар мөн. Аюулыг урьдчилан харна гэдэг нь явцуу утгаар тагнуулын мэдээг үр дүнтэй ашиглах явдал юм. Харин болзошгүй аюулын өөдөөс урьдчилан бэлтгэлээ хангаж шийдвэртэй ажиллан эцэст нь амжилтанд хүрэх чадвар бол хил хамгаалах байгууллагын хувьд иж бүрэн цогц арга хэмжээний нэгдэл байна. Энэ нь өндөр үр ашигтай зэвсэглэл, техникийг хил хамгаалалтад нэвтрүүлж, тэдгээрийн боломжийг дээд зэргээр ашиглаж чадах боловсон хүчинтэй байх, хилчдэд мэргэжлийн ур чадвар суулгах, эх оронч сэтгэлгээтэй дайчин болгох. ямар ч нөхцөлд үйл ажиллагаа явуулах бүх талын материал. санхүүгийн найдвартай. тасралтгүй хангалт үйлчилгээний тогтолцоо бүрдүүлэх, цэргийн тасралтгүй удирдлагыг тогтвортой уян хатан чанд хэлбэрээр зөв хослон хэрэгжүүлэх зарчим, арга хэмжээнээс бүрдэнэ.

Монгол Улсын хил хамгаалалт нь агуулгаараа өргөн ба явцуу хэлбэрээр амьдралд хэрэгжинэ. Хил хамгаалалтыг өргөн утгаар нь авч үзвэл Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг найдвартай хангах улсын аюулгүйн байдлын баталгааны нэгэн илэрхийлэл мөн.

Ийм учраас төр засгийн удирдагчид улс орныхоо бололцоог тооцон бодлого, төлөвлөгөөтэйгээр улсын хилээ найдвартай хамгаалах арга хэмжээ авна.

Улсын хил хамгаалалтын явцуу хүрээний ойлголтод улсын хилийг гардан хамгаалж байгаа хилийн цэргийн үйл ажиллагаа хамаарагдана. Энд өвөрмөц онцлог бий. Төр нь Монгол улсын хилийг тогтоож, засаг нь хилээ найдвартай хамгаалахад хүрэлцэхүйц мэргэжлийн өндөр чадавхтай хүч хэрэгсэл, хөрөнгөөр хилийн цэргийг найдвартай хангаж удирддаг байх ёстой. Харин олгогдсон хүч хэрэгсэл, хөрөнгийг дээд зэргийн ашигтайгаар хил хамгаалалтад ашиглах хариуцлагыг хилийн цэргийн дарга хүлээдгээрээ онцлогтой боловч харилцан шүтэлцээтэй, нэгдмэл үйл ажиллагааны үр дүнд улсын хил найдвартай хамгаалах боломж болдог байна.

Монгол Улсын хил хамгаалалт хэдий чинээ найдвартай байх тутам төдий хэмжээгээр улсын хилийг өөрчлөх санаархал, зөрчих элдэв оролдлого таслан зогсоогдож, улс орны аюулгүйн байдал энхжин батжиж, улсын батлан хамгаалахад шаардагдах зардлыг хэмнэх, эх орноо эрчимтэй хөгжүүлэх бололцоогоор хангагдана.

ДҮГНЭЛТ: Хил хамгаалалтын нэгдмэл тогтолцоог бүрдүүлэхэд дараах хучин зүйлийг харгалзан үзэх шаардлагатай.

1. Монгол Улсын хил хамгаалалт, улсын хилээр зорчигч тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх ажиллагаа нь дэлхий нийтийн тухайн үйл ажиллагааны салшгүй хэсэг мөн. Иймд тэдгээрийн төвшингээс хил хамгаалах байгууллага, хилчид хохрох ёсгүй.

2. Улс орнуудтай сайн хөршийн найрамдалт харьцаатай байх бодлого нь улсын хилийн халдашгүй дархан байдалтай харилцан шүтэлцээтэй явагддаг.

3. Монгол улсын хил хамгаалалтын бодлого уйл ажиллагаа нь Үндсэн хуулийг дээдэлдэг, төр, засгийн бодлого үйл ажиллагаатай нягт уялдаа холбоотой байдаг.

4. Улсын хил хамгаалалт нь Монгол Улсын батлан хамгаалалтын салшгүй хэсэг боловч хил хамгаалах байгууллагын хүчин чадал, түүний ажиллагааны чадавхаас үндэсний аюулгүй байдал шалтгаалдаг.

5. Нэгэнт тогтоогдсон улсын хилийг өөрчлөх, зөрчих бололцоо нөхцөл гаргахгүй байхын тулд хил хамгаалах мэргэжлийн байгууллага, хүч хэрэгслээр тасралтгүй хамгаалдаг.

6. Улсын хилийн дагуу болон хил орчмын нутаг дэвсгэрийг инженер, техникийн хэрэгслээр зохих журмаар төхөөрөмжлөх нь улсын хилийг мөнхийн баталгаатай болгох, хил зөрчих явдлыг багасгах, зардал, хөрөнгө хэмнэгдэх бололцоо олгодог.

Монгол Улсын хил гэж тодорхойлогддог тэрхүү шугам нь чухамдаа бас хөрш улсын хилийн шинжийг агуулдаг бөгөөд айл зэргэлдээ улстай хамтран зөвшилцөж, олон улсын эрх бүхий байгууллагаар баталгаажсан учраас Монгол улс хилийнхээ шугам, багана, тэмдэг, холбоосыг найдвартай хамгаалах арга хэмжээ авснаар олон улсын зарчмаас гажих, хөршийнхөө итгэлийг эвдэх бус харин хоёр улсын найрамдал, ард түмний нөхөрлөл, хамтын ажиллагааг улам бэхжүүлэх, “хоёр улс, нэг хил” гэсэн зарчмыг баримтлан Монгол улсын нэр хүндийг дэлхий дахинд өргөж, олон улсын талархал хүлээж, монголын ард түмэн олон зуун жил амар түвшин аж төрөх нөхцлөөр хангагдах болно.